

ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ГУРВАНТЭС СУМЫН БАЯСАХ
БАГИЙН НУТАГТ БАЙРЛАХ “ЗАНГАТ-УУЛ1” ТӨСЛИЙН
2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР 5217652 /

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГЕСТРИЙН ДУГААР MV-016952./

Хянасан:

БОАЖЯ-НЫ ХБОБНУГ-ЫН шинжчээч:

Ч.Жаргалнэмэх

Биелэлтийг тайлагнасан:

ЖАВХЛАНТ ОРД ХХК-ийн гүйцэтгэх захирал:

Mengheqilu

ЖАВХЛАНТ ОРД ХХК-ийн
Байгаль орчны мэргэжилтэн:

Ч.Монгол-Эрдэнэ

2022 он



| | |
|---|----|
| НЭГ. УУРХАЙНТОВЧ ТАНИЛЦУУЛГА..... | 4 |
| ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ..... | 12 |
| 2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 12 |
| ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ | |
| 3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | 16 |
| 3.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт..... | 17 |
| 3.3. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 26 |
| 3.4. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 26 |
| 3.5. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт..... | 26 |
| 3,6, осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 27 |
| 3.7. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт..... | 27 |
| 3.8. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, түүний үр дүнг тайлагнах, хэлэлцүүлэх төлөвлөгөөний биелэлт..... | 29 |
| 3.9 Аймаг, нийслэлийн засаг даргын шаардлагаар биелүүлсэн арга хэмжээ..... | 30 |
| 3.10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт..... | 32 |
| 3.11 Тухайн жилийн менежментийн төлөвлөгөө , төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт..... | 33 |
| ДҮГНЭЛТ | |



ЗУРГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|----|
| Зураг 1. Ордын байрлал..... | 4 |
| Зураг 2. MV-016952 тоот тусгай зөвшөөрлийн талбайн сансрын зураг..... | 5 |
| Зураг 3. Баруун зүүн ил уурхайнуудын ерөнхий хэмжээс..... | 7 |
| Зураг 4. Уулын ажлын механикжуулалтын бүтэц..... | 8 |
| Зураг 5. Уурхайн боловсон хүчний баг бүрэлдэхүүн..... | 8 |
| Зураг 6. Баригдаж буй нүүрс тээврийн хатуу хучилттай зам..... | 9 |
| Зураг 7. Одоогийн байгаа уурхайн ажилчдын тосгон..... | 10 |
| Зураг 8. Шинээр төлөвлөж буй ажилчдын тосгон..... | 11 |
| Зураг 9. Тэсрэх материалын агуулах..... | 11 |
| Зураг 10. Гурвантэс наадмийн талбайд мод тарьж буй байдал..... | 12 |
| Зураг 11. Зэрлэг амьтдад идэж тэжээл, мөс дөхүүлж буй байда..... | 13 |
| Зураг 13. Бохирын цооног..... | 14 |
| Зураг 14. Багийн иргэдийн нийтийн хуралд уурхайн үйл ажиллагааны тайланг танилцуулж буй байдал..... | 15 |
| Зураг 15. Хөрсний дээжлэлт, мониторингийн цэгүүд..... | 16 |
| Зураг 16. Ургамлын бичиглэл, мониторингийн цэгүүд | |
| Зураг 17. Ургамлын бичиглэл хийж буй байдал | |

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

| | |
|--|--|
| Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлууд | |
| Хүснэгт 2. Уурхайн талбайд хийсэн ургамлын бичиглэл | |
| Хүснэгт 3. 2021 онд байгаль орчин менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийгдсэн ажлууд | |
| Хүснэгт 4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт | |
| Хүснэгт 5. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хэрэгжилт (Хөрс) | |
| Хүснэгт 6. Байгаль орчныг хамгаалах ажлын зардлын задаргаа | |




ЗАНГАТ УУЛЫН ЧУЛУУН НҮҮРСНИЙ УУРХАЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ерөнхий мэдээлэл

“Жавхлант-Орд” ХХК нь 2011 оны 04-р сарын 12-нд байгуулагдсан ба Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Зангат уул-1 нэртэй газарт орших 29100.14 га талбайд MV-016952 дугаарын ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийг 2011 оны 11-р сарын 18-ны өдөр 30 жилийн хугацаагаар авсан байна.

Зангат уул-1 нэртэй ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбай нь Улаанбаатар хотоос 680 км, Даланзадгад хотоос 300 км, Гурвантэс сумын төвөөс 27 км зайд Өмнөговь аймгийн Гурвантэс сумын 4-р багийн нутаг дэвсгэрт оршдог. Тус орд нь К-47-35, К-47-2 номенклатурт байрладаг.



Зураг 1. Зангат уулын нүүрсний ордын байршил

“Жавхлант орд” ХХК нь ашиглалтын MV-016952 тусгай зөвшөөрөл эзэмшдэг бөгөөд уг талбай нь 29100.14 га газрыг хамардаг. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийг дараах хүснэгтэд үзүүлэв.

Хүснэгт 1. Тусгай зөвшөөрлийн талбайн булангийн цэгүүдийн солбицлууд

| д/д | WGS-84 | | UTM | |
|-----|-----------------|------------------|-------------|------------|
| | Өргөрөг | Уртраг | X, м | Y, м |
| 1 | 430 21I 01.31II | 1010 17I 56.95II | 4802290.411 | 686334.816 |
| 2 | 430 19I 46.00II | 1010 17I 56.95II | 4799967.093 | 686398.836 |
| 3 | 430 19I 46.00II | 1010 22I 25.89II | 4800136.673 | 692455.631 |
| 4 | 430 20I 33.56II | 1010 22I 25.89II | 4801603.906 | 692413.888 |
| 5 | 430 20I 33.56II | 1010 29I 25.25II | 4801879.174 | 701856.278 |
| 6 | 430 15I 48.46II | 1010 29I 25.25II | 4793083.794 | 702118.640 |
| 7 | 430 15I 48.46II | 1010 22I 33.66II | 4792813.551 | 692839.140 |
| 8 | 430 14I 55.28II | 1010 22I 33.66II | 4793023.947 | 692833.157 |
| 9 | 430 14I 55.28II | 1010 19I 00.68II | 4792889.099 | 688031.586 |
| 10 | 430 14I 01.30II | 1010 19I 00.68II | 4789372.853 | 688129.061 |
| 11 | 430 13I 01.30II | 1010 19I 00.68II | 4787521.879 | 688180.350 |
| 12 | 430 13I 01.30II | 1010 14I 09.17II | 4787342.847 | 681603.158 |
| 13 | 430 13I 45.00II | 1010 14I 09.17II | 4788690.968 | 681567.111 |
| 14 | 430 13I 45.00II | 1010 15I 56.00II | 4788755.839 | 683976.980 |
| 15 | 430 15I 28.00II | 1010 15I 56.00II | 4791933.346 | 683890.857 |
| 16 | 430 15I 28.00II | 1010 07I 46.00II | 4791642.822 | 672842.649 |
| 17 | 430 21I 01.31II | 1010 07I 46.00II | 4801925.332 | 672580.417 |
| 18 | 430 21I 01.31II | 1010 11I 46.00II | 4802065.406 | 677983.558 |
| 19 | 430 19I 46.00II | 1010 11I 46.00II | 4799742.097 | 678044.706 |
| 20 | 430 19I 46.00II | 1010 14I 41.00II | 4799846.955 | 681985.860 |
| 21 | 430 21I 01.31II | 1010 14I 41.00II | 4802170.268 | 681923.357 |

2010-2011 онуудад Зангат уулын чулуун нүүрсний ордын төв хэсэгт хайгуулын ажлыг гүйцэтгэж, үр дүнг нэгтгэн боловсруулж Ашигт малтмалын газрын даргын 2011 оны 9-р сарын 14-ний өдрийн 389 тоот дүгнэлтээр А+В+С зэргээр 28.09 сая тонн нүүрсний нөөцийг ашигт малтмалын улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн.

“Жавхлант орд” ХХК нь Гурвантэс сумын Баясах багийн нутагт байрлах Зангат уулын чулуун нүүрсний ордод Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрхзүйн хүрээнд олборлолтын ажил явуулж байна.

Хүснэгт 2. Захиргаа болон дэд бүтцийн ерөнхий мэдээлэл

| Төслийн нэр | Хэрэгжүүлэгч | Төслийн зорилго | Төслийн бүсийн дэд бүтэц | Төслийн барилга, байгууламж |
|---|---|--|---|---|
| “Зангат Уул” чулуун нүүрсний орд MV-016952 Тусгай зөвшөөрлийн талбай 29100.14 га | “ЖАВХЛАНТ ОРД” ХХК Гэрчилгээ: 9019058049 Хаяг: УБ, ХУД- 1р хороо, “Их Хуралдай бизнес төв ” байр, 1001 тоот Утас: 77111101 | Чулуун нүүрс олборлож, улс орны эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх | Хүн амын нягтшил бага бүсэд (1км-г 0.2 хүн)төсөл байршина.Гурван Тэс сум 4000 хүн амтай. 4 багтай. Хүн, малын эмнэлэгтэй, 8 жилийн сургуультай.Хөдөлмөр эрхлэлтийн 90% нь мал аж ахуй эрхэлдэг. Уурхай нь төв суурин газруудтай шороон замаар холбогддог.Нүүрсний гадаад тээвэрт хатуу хучилттай хүнд даацын зам тавихаар төлөвлөсөн.Уурхайгаас Овоот толгойн нүүрсний уурхай хүртэлх 45 км замыг өөрийн хөрөнгөөр тавихаар төлөвлөсөн. | Далд уурхай, захиргаа, орон сууцны түр байрууд, цахилгаан хангамж-дэд болон дизель станц, усан хангамж-гүний худаг, засварын газар, хоолны газар, тэсрэх бодисын агуулах зэрэг болно. |

Зангат уулын чулуун нүүрсний уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайлан болон Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 -ны өдрийн А-618 дугаар тушаал “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу боловсруулав.



Төсөл хэрэгжүүлэгч нь тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг 11 дүгээр сарын 01-ий дотор аймгийн байгаль орчны газарт хүргүүлнэ.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг хүлээж авсан аймгийн Байгаль орчны газар түүний биелэлтийг шалгаж, дүгнэлт гаргах ажлын хэсгийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулж, ажилуулан дүгнэлтийг 12 дугаар сарын 1-ний дотор гаргуулна.

Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайлан, түүнд хийсэн ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, биелэлтийг хянаж, дараагийн жилд хэрэгжүүлэх байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулна.

Бид үйл ажиллагаандаа байгаль орчныг хамгаалах ажлуудыг авч хэрэгжүүлдэг бөгөөд цаашид ч мөн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, байгаль хамгаалах санаачлага, туршлагуудыг нэвтрүүлэн ажиллах болно.




Төслийн хүчин чадал, ажиллах горим

Баян-Ундарга уурхай нь жилд 1.000.000.тн нүүрс олборлох хүчин чадалтай.

Уурхай нь жилийн 365 хоног тасралтгүй ажиллана. Орд ашиглалтын хугацаанд нийт 11.9 сая.м3 хөрс хуулж 1 сая.тн нүүрс олборлоно.

Зангат-Уулын орд нь зүүн болон баруун гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэх бөгөөд уг ордууд хоорондын зай нь 2 км байна. Үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий нүүрсний давхаргуудын зузаан дунджаар 1.25-13.2 метр бөгөөд баруун ордын хувьд нүүрсний давхарга нь 3.4 км урт сунаж тогтдог бол зүүн орд хувьд 3.7 км урт сунаж тогтдог.



Зураг 2. Баруун зүүн ил уурхайнуудын ерөнхий хэмжээс



Геологи хайгуулын ажлаар уг хоёр талбайд нийтдээ хоёр үндсэн нүүрсний давхаргуудаас тогтсон ба уналын өнцөг нь зүүн хойш 60-70 хэмээр сунаж, зүүн ургаш 45-65 градусаар унаж тогтсон байна. Ордын байгаа район нь ус ихтэй гэж таамаглаж байгаа бөгөөд олборлолтын үед уснаас хамгаалах, ус таталтын технологийг сонгож ажиллаж байна.

Газрын гадаргуу нь бага зэрэг налуу ч олборлолтын явцад ямарваа нэгэн хүндрэл үүсэхгүй. Мөн ордын талбайгаар цас борооны ус, урсдаг жалга байрладаг учир олборлолтын явцад гадаргын уснаас хамгаалах суваг, шуудуу татах шаардлагатай.

Хөрсний эзлэхүүн жин - 2.5 тн/м³


Нүүрсний эзлэхүүн жин (орд баруун хэсэг) - 1.56 тн/м³

Нүүрсний эзлэхүүн жин (орд зүүн хэсэг) - 1.49 тн/м³

Хөрсний чулуулгийн бат бэхийн коэффициент Профессор М.М.Продотьяконовын ангиллаар $f=3-7$ байна.

Зангат-Уулын ордын баруун хэсэг нь 45-70 градусын уналтай газрын гадаргуугаас 400 метр бол зүүн хэсэг нь 37-50 градусын уналтай газрын гадаргуугаас 270 метрийн гүнд тус тус сунаж тогтдог. Тус ордын нүүрсний биетийн геологийн тогтцын үзүүлэлтүүдээс хамааруулан ордыг гадаад овоолготой автотээвэртэй ашиглалтын системээр ашиглаж байна.

Баян-Ундарга ил уурхайн уулын ажлын механикжуулалтын бүтцийн схемийг дараах зурагт үзүүлэв.



Зураг 3. Уулын ажлын механикжуулалтын бүтэц

Бид 2022 онд 529.305 м³ хөрс хуулалтын ажил гүйцэтгэж 35.653 тн нүүрс орлборлож, 94.900 тн нүүрс экспортлоод байна.

Уг уурхайн олборлолтын улмаас одоогийн байдаар нийт 230 га тайлбай нөлөөлөлд өртсөн байна.



2022 оны байдлаар уурхайд нийт 190 ажилчинтай үйл ажиллагаа явуулсан бөгөөд нийт ажилчдын 40 гаруй хувийг Гурвантэс сумаас авч ажиллуулсан



Зураг 4. Уурхайн боловсон хүчний баг бүрэлдэхүүн

Хүснэгт 3. Уурхайн нөөцийн хаягдал, бохирдол

| Үзүүлэлт | Нэгж | Ашиглалтын жилүүд | | | Нийт |
|------------------|------|-------------------|-----------|-----------|-----------|
| | | 1 | 2-7 | 8 | |
| Үйлдвэрийн нөөц | Тн | 1.000.000 | 1.000.000 | 1.000.000 | 8.000.000 |
| Хаягдал | % | 3.3 | 3.3 | 3.3 | |
| Хаягдлын хэмжээ | Тн | 33.000 | 33.000 | 33.000 | 99.000 |
| Бохирдол | % | 4.1 | 4.1 | 4.1 | |
| Бохирдлын хэмжээ | Тн | 35424 | 41000 | 41000 | 322.424 |
| Борлуулах нүүрс | тн | 637632 | 738000 | 738000 | 5803632 |

Хүснэгт 4. Ордын нүүрсний чанарын мэдээлэл

| Дээжлэгдсэн байдал | Чийглэг | Дэгдэмхий бодис | Үнслэг | Хүхэр | Дулаан гаргах чадвар | Нүүрсний эзлэхүүн жин | Нүүрсжилт |
|---|---------|-------------------|-------------|---------------------|----------------------|-------------------------|--|
| 2010, 2011 онуудад нийт 163 кернтэй дээж шинжлүүлсэн. | W=12.7% | 26 % Чулуун нүүрс | 22.7% - 25% | 0.7 % Бага хүхэртэй | 6065 ккал/кг | 1.56 гр/см ³ | Моноклиналъ структуртай. Дэлийн Шандын формацын нүүрс. Бутрамтгай, нунтаг байдалтай байна. |

Баян-Ундарга уурхай нь ажилчдын тосгон, засварын цех, стандартын шаардлага хангасан тэсрэх материалын агуулах, гаалийн хяналтын талбай зэрэг барилга байгууламжуудтай. “Жавхлант орд” ХХК нь уурхайн ашиглалттай холбоотой дэд бүтэц, бүтээн байгуулалтын ажлуудыг гүйцэтгэж байна. Үүнд:

2022 онд нүүрс тээвэрлэлтийн асуудлыг шийдвэрлэж уурхайгаас улсын хил хүртэл хатуу хучилттай зам тавьж эхлээд байна.

Мөн ажилчдын ая тухтай байдлыг хангахын тулд ажилчдын тосгоныг барилгажуулахаар төлөвлөөд байгаа ба шинэ тосгоны зураг төслийг боловсруулсан.



Зураг 5. Баригдаж буй нүүрс тээврийн хатуу хучилттай зам



Дэд бүтэц

Тээрэх материалын агуулах



Засварын цех



Зураг төслийн ажлыг гүйцэтгэж дууссан “ГОЛДМЭН ПРОЖЕКТ” ХХК

2021 оны 3 дугаар улиралд 1-р ээлж ашиглалтанд орно.

2022 оны 3 дугаар улиралд 2-р ээлж ашиглалтанд орно

Хөрөнгө оруулалтын хэмжээ 2.5 тэрбум төгрөг

Гаалийн хяналтын талбай



ШТС



Зураг 6. Одоогийн байгаа уурхайн ажилчдын тосгон





Зураг 7. Шинээр төлөвлөж буй ажилчдын тосгон



Зураг 8. Тэсрэх материалын агуулах



ХОЁР. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

2.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Газрын хэвлийгээс ашигт малтмалыг олборлох бүх арга технологиуд газар ба түүний хэвлийг хөндөж, экологийн тэнцвэртэй байдалд шууд ба дам байдлаар төсөл хэрэгжиж дуусах хүртэлх хугацаанд их эрчимтэйгээр нөлөөлдөг онцлогтой. Голлох сөрөг нөлөөллийг дараах байдлаар тодорхойлон үзүүлэв. Үүнд:

Агаарын орчин

Уурхайн техник, технологийн үйл ажиллагааны нөлөөгөөр үүсэх тоос шороо болон хорт хий агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно. Уурхайн карьерт хөрс хуулах, нүүрс олборлох үед үүсэх тоос, тээврийн хэрэгсэл явах үед боссон автозамын тоос, хүнд даацын машин, механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтын хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хорт хий, уурхайн малталтууд болон зам талбайгаас салхинд хийсэх тоос, хөрс болон нүүрсийг тээвэрлэх үед үүсэх тоос шороо гарна.

Овоолгын аж ахуйд тээврийн хэрэгсэл явах үед боссон авто замын тоос, машин механизм, тоног төхөөрөмжийн дотоод шаталтын хөдөлгүүрээс гарах утаа болон хорт хий, хөрс буулгах, түрж тэгшлэх үед үүсэх тоос, овоолгоос салхинд хийсэх тоос, шороо агаар орчныг бохирдуулах эх үүсвэр болно.

Иймд 2022 онд Агаарын тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор тоосжилт болон хуурайшилт их үед тоосжилтын шинжилгээг хийж зам талбай болон уурхайн тосгоны замыг тогтмол усалгаа хийж ажиллалаа.

Хөрсөн бүрхэвч

“Зангат уул” төслийг хэрэгжүүлжэхэлснээр орчны үржил шимт хөрс болон малын бэлчээр бүхий талбай уурхайн малталт болон барилга байгууламж, хүнд даацын машин техникийн үйл ажиллагааны нөлөөнд өртөж, хөрсний элэгдэл, эвдрэл, бохирдол үүснэ.

Иймд “Баян-Ундарга” уурхайн засварын газрын орчим асгарсан нефтийн гаралтай бүтээгдэхүүнийг саармагжуулах ажлыг тогтмол хийж гүйцэтгэсэн. Мөн хүнд элементийн бохирдлын шинжилгээ болон хөрсний химийн ерөнхий үзүүлэлтүүдийн шинжилгээг улирал тутамд хийлгэн ажилласан.



Ургамлан бүрхэвч

“Баян-Ундарга” чулуун нүүрсний ордыг ашиглаж эхэлснээр малын бэлчээрийн зориулалтаар ашиглагдаж байгаа талбайн ургамлан нөмрөгт сөрөг нөлөөлөл үзүүлнэ.

Ургамлын хяналт, мониторингийг хэрэгжүүлэх зорилгоор уурхайн талбайд ургамлын бичиглэл хийж, мониторингийг улирал тутам зохион байгуулж байна. Үүнд:

Бичиглэлийн судалгааны арга зүйг ашиглаж байгаа бөгөөд уурхайн тосгон болон уурхайн олборлолт явуулж буй талбай, хөндөгдөөгүй эрүүл 3 газрыг сонгон авч нийт 22 зүйлийн ургамлын бичиглэлийг хийгээд байна.

Хүснэгт 5. Уурхайн талбайд хийсэн ургамлын бичиглэл

| № | Ургамлын нэр (Монгол) | Ургамлын нэр (Латин) | Амьдралын хэлбэр |
|----|-----------------------|--|--------------------|
| 1 | Монгол сонгино, хөмөл | <i>Allium mongolicum</i> Rgl. | Алаг өвс |
| 2 | Намхан гишүүнэ | <i>Rheum nanum</i> Sievers. | Алаг өвс |
| 3 | Таана | <i>Allium polyrrhizum</i> Turcz. ex RgL. | Алаг өвс |
| 4 | Марцны аргамжин цэцэг | <i>Cistanche salsa</i> (C. A. Mey.) G. Beck | Алаг өвс |
| 5 | Ахар навчит баглуур | <i>Anabasis brevifolia</i> C. A. Mey. | Зармидаг сөөгөнцөр |
| 6 | Бор бударгана | <i>Salsola passerina</i> Bge. | Зармидаг сөөгөнцөр |
| 7 | Горчаковын сэдэргэнэ | <i>Convolvulus Gortschakovii</i> C., | Зармидаг сөөгөнцөр |
| 8 | Зүүнгарын бутаргана | <i>Reaumuria songorica</i> (Pall.) Maxim. | Зармидаг сөөгөнцөр |
| 9 | Орог тэсэг | <i>Eurotia ceratiodes</i> (L.) C. A. Mey | Зармидаг сөөгөнцөр |
| 10 | Өргөст ортууз | <i>Oxytropis aciphylla</i> Ldb. | Зармидаг сөөгөнцөр |
| 11 | Сибирь хармаг | <i>Nitraria sibirica</i> Pall. | Зармидаг сөөгөнцөр |
| 12 | Хулан хойрго | <i>Potaninia mongolica</i> Maxim. | Зармидаг сөөгөнцөр |
| 13 | Хуурайсаг шарилж | <i>Artemisia xerophytica</i> Krasch. | Зармидаг сөөгөнцөр |
| 14 | Тарваган харгана | <i>Caragana pygmaea</i> (L.) DC. | Сөөг |
| 15 | Шар хотир | <i>Zygophyllum xanthoxylon</i> (Bge.) Maxim. | Сөөг |
| 16 | Улалж | <i>Carex</i> sp. | Улалж |
| 17 | Говийн хялгана | <i>Stipa gobica</i> Roshev. | Үетэн |
| 18 | Зүүнгарын хазаар өвс | <i>Cleistogenes songorica</i> (Roshev.) Ohwi. | Үетэн |
| 19 | Өргөст бударгана | <i>Salsola pestifera</i> Nels. | Цөөн наст |
| 20 | Амманы сэдэргэнэ | <i>Convolvulus Ammanii</i> Desr. | Цөөн наст |
| 21 | Харлаг өмхий өвс | <i>Peganum nigellastrum</i> L. | Цөөн наст |
| 22 | Үслиг манан хамхаг | <i>Bassia dasyphylla</i> (Ficsh. et Mey.) Ktze | Цөөн наст |

Усны нөөц, чанар

“Баян-Ундарга” чулуун нүүрсний орд орчимд гадаргын усан сүлжээ байхгүй учир унд-ахуй болон технологийн усны хэрэгцээнд гүний худгийн усыг хэрэглэнэ.

“Баян-Ундарга” чулуун нүүрсний ордыг ашиглах үед жилд дунджаар 42 мян.м³ ус шаардагдах ба ашиглалтын хугацаанд нийт 294 мян.м³ гүний ус хэрэглэнэ. Тус хэрэглээг хангахад уурхайд одоо байгуулсан худгийн ундарга хангалттай хүрэлцэхээр байна.

Хотхоны усны хэрэглээг тооцохдоо нэг хүн хоногт 150л ус хэрэглэхээр тооцсон ба ил уурхайд зам талбай услах, тоос дарахад ус ашиглана.

Ус агуулагч чулуулаг нь, элсэн чулуу, жижиг дунд хэмжээтэй хайргатай хөрзөн чулуу, карбонатлаг барьцалдуулагчтай элсжин, зануужингаас бүрдэнэ. Химийн найрлагаараа холимог сульфат-гидрокарбонат-хлорын, сульфат-хлор-гидрокарбонатын натри-кальц-магнийн төрлийн ус зонхилон тархсан. Эрдэжилт харьцангуй өндөр 1.3-5.4 г/л үзүүлэлттэй. Түүний хатуулаг 12 мг-экв/л-ээс дээш, маш их хатуулагтай.

Тайлант онд Усны тухай хууль, Ариун цэврийн тухай хуулиудаас гадна усны стандартын шаардлагуудыг мөрдөж ажилласан. Үүнд:

- Гүний худганд химийн болон бактерийн шинжилгээг аймгийн Мэргэжлийн хяналтын газрын сорилтын лаборатороор шинжилгээ хийлгэсэн
- Гүний худагт ариун цэврийн бүс тогтоосон
- Ус ашиглах гэрээ, гүний болон ундны усанд тоолуур суурилуулсан

Амьтны аймаг

Тус районд тархсан биологийн төрөл зүйл нь хоорондын хэлхээ холбоо, түүгээр уламжлан энергийн эргэлтэд тодорхой үүрэг гүйцэтгэдэг. Хөрсөнд амьтны аймгийн ангилалзүйн олон төлөөлөгч амьдарч, өвөрмөц биоценозыг бүрэлдүүлдэг.

Эндэхийн амьтад бүгд идэш тэжээлийн нягт эмзэг хэлхээ холбоонд оршин тогтнох бөгөөд эдгээрийн аль нэг нь дутагдах юм уу үхэж мөхөхөд бусад төрөл зүйлийн хэвийн амьдрал алдагдан доройтох зүй тогтолтой.

Олборлолтын үйл ажиллагаагаар амьтны аймгийн төлөөлөгчдийн орогнох орон байр, идэш тэжээл, үржил, хөгжил, зүйл хоорондын харилцан шүтэлцээ тодорхой хэмжээгээр өөрчлөгдөх эрсдэлтэй.

2022 онд уурхайн үйл ажиллагаанд амьтны аймагт сөрөг нөлөөлөл үзүүлээгүй.



Геологийн тогтоц, газрын гадарга, хэвлий

“Жавхлант Орд” ХХК “Баян-Ундарга” чулуун нүүрсний ордыг ил аргаар ашиглах учир уурхайн үйл ажиллагаанаас газрын гадарга болон хэвлийд дараах байдлаар шууд нөлөөлнө. Үүнд:

- Газрын хэвлий ухагдан онгилогдож ландшафтын хэлбэр дүрс хүчтэй өөрчлөгдөн байгалийн унаган төрх алдагдаж хамгийн ихдээ 5000 м урттай, 3000 м өргөнтэй, 60 м гүнтэй ил уурхайн хоосон орон зай үүснэ.

- Ил уурхайн үйл ажиллагаагаар газрын хэвлийгээс 5711507 м³ хөрс хуулагдаж, 635881 тн нүүрс олборлоно(хөрс хуулалтын итгэлцүүр 9.55 м³/тн).

2022 онд уурхай үйл ажиллагаанд газрын гадарга, хэвлийд сөрөг нөлөөлөл үзүүлээгүй. Харин Газрын тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд олон салаа зам гаргахгүйгээр нэг чиглэлийн замаар зорчиж аюулгүй ажиллагааг мөрдөн ажилласан. Мөн хогийн цэг болон тос, тосолгооны материал асгарч болзошгүй бохирдуулагч эх үүсвэрүүдээс сэргийлж талбайг бетон хашаажуулсан.



ГУРАВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний 2022 оны тухайнжилийн гол зорилт

2022 онд “Зангат уул” төслийн ажлыг эхлүүлэх, нүүрсний нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор өрөмдлөг хайгуулын ажлыг явуулах, холбогдох дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэх (зам барих)гэх мэт.

Төлөвлөгөөт онд байгаль орчны хамгааллын чиглэлээр дараахь гол зорилтуудыг дэвшүүлэн ажилласан болно. Үүнд:

- Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх байгаль орчны бүрдэл хэсгүүдэд нөлөөлөх сөрөг нөлөөллийг аль болох бага хэмжээнд байхад анхаарах,
- Уурхайн үйл ажиллагаанд Монгол улсын хууль, тогтоомж, стандартыг мөрдөн ажиллах г.м

Байгаль орчинд учруулах сөрөг нөлөөллийг байгаль орчны бүрдэл хэсэг бүрээр тодорхойлон гаргасан бөгөөд 2022 оны БОМТ-г хэрэгжүүлэх явцад төлөвлөгөөнд тусгасан ажил бүрийг тодорхой хэмжээгээр хэрэгжүүлэн ажилласан.

2022 онд байгаль орчны хамгаалах менежментийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хөрсөн бүрхэвч, агаар орчин, газар доорх ус, биологийн олон янз байдал, газар, нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал болон нийгмийн хариуцлагын хүрээнд нийт 36 ажилд төлөвлөн ажилласан бөгөөд ажлын гүйцэтгэл 94.4 % -ийн биелэлттэй байна.



ТАВ . Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

| | Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд | Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ | Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ | Хэмжих нэгж | зардал, төг | Тоо хэмжээ | Ажлын биелэлт тайлбар | Биелэлт |
|---|--|---|--------------------------------------|--------------------|--------------------|-------------------|--|----------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| <i>Агаарын чанарт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө</i> | | | | | | | | |
| 1 | Нүүрс тээврийн замын тоосжилтыг бууруулах | Нүүрс тээврийн замын тоосжилтийг бууруулах зорилгоор засвар үйлчилгээ, усалгааг тогтмол хийх | Уурхайн, Кемп, дотоод зам | Улирал бүр | ОХШХ тусгагдсан | Жилийн турш | Уурхайн лотоод болон тээврийн замыг нийт 5 усалгааны машинаар 7 хоног тутам усалгааг гүйцэтгэсэн | 100 |
| 2 | | Олон салаа зам болон сайжруулсан шороон замаас бусад ашиглагдаж байсан замыг ашиглахаа больж, нөхөн сэргээх | Тээврий зам | | Дотоод зардалд | Жилийн турш | Сумын болон Нүүрс тээврийн замыг гарц, орцыг хааж, үерт эвдэрсэн замыг нөхөн сэргээж, хусч сайржуулж янзалсан. | 100 |
| <i>Гадаргын ба газрын доорхи усны нөөцөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө</i> | | | | | | | | |
| 3 | Уурхайн ус зайлуулалтаас ордын ойр орчмын бүс нутагт газар доорхи усны түвшин буурах | Гүний усны хэрэглээг багасгах зорилгоор шүүрүүлэлтийн усыг ногоон байгууламжийн усалгаанд ашиглах | Уурхайн шүүрлийн ус | Жилийн турш | ОНХШХ тусгагдсан | Жилийн турш | Шүүрлийн усаар ногоон байгууламж болон дотоод зам далбайг 7 хоног бүр усалгааг гүйцэтгэсэн | 100 |
| 4 | | Гүний худагт усны тоолуур суурилуулан баталгаажуулах | Уурхайн унд ахуйн худаг | 2021 оны 3 сар | 1.200.0 | 1 удаа | Тоолуур суурилуулж сумын байгаль хамгаалчтар баталгаажуулж ажиллсан. | 100 |
| 5. | Хөв цөөрөм хийх | Уурхайгаас гарч буй шүүрлийн усыг усан санд байршуулах батлагдсан төслийн дагуу усан сангийн ажлыг эхлүүлэх | Ил уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Жилийн турш | 5.000.0 | Жилийн турш | Усан сангийн зураг төслийг гаргаж 2021 онд эхний далангийн ажлыг гүйцэтгэсэн. | 100 |



| | | | | | | | | |
|----|---------------------------------|---|--|-----------------------------|--|-------------|---|-----|
| 6 | Усны чанарт үзүүлэх нөлөөлөл | Орон нутгийн захиргаатай хамтран булаг, шанд тохижуулах | Баясах багт | 2022 оны 9 сард | 5.000.0 | 1 удаа | Баясах багийн засаг даргаас чиглэл авч Хонингын булгийг хашиж тохижуулсан. | 100 |
| 7 | Ус ашигласны төлбөр тооцоо хийх | Гүний худгаас дээж авч унд-ахуйн хэрэглээний чанарын шинжилгээ хийлгэх | шүүрлийн ус, худаг, малчдын гар худаг, бохир | Улирал бүр | 200.000 | Жилийн турш | ӨМ аймгийн ЦУОШГт ус, хөрс агаарын шинжилгээг улирал тутамд хийж гүйцэтгэсэн | 100 |
| 8 | | Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авч, гэрээ байгуулах, усны нөөц ашигласны төлбөр хураамжийг сар бүр орон нутгийн төсөвт төвлөрүүлэх | Усны газар, ӨМА, АОГСГЗ, Гурвантэс сум | 2022 | Дүгнэлтээр үндэслэн | 12 сард | Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрлийг холбогдох байгууллагуудаас авч, гэрээ байгуулан ажилсан | 100 |
| 9 | | Ус ашиглах дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх | Төслийн хэмжээнд | Ил Уурхай, Гэрээт компаниуд | - | Жилийн турш | Ус ашиглах дүгнэлтэнд зааснаас бусад зориулалтаар ус ашиглах, бусдад худалдан борлуулах, төлбөр хураамжийг хугацаанд нь төлөхгүй байх зэрэг Усны тухай хууль тогтоомж зөрчсөн үйлдэл гаргахгүй байх талаар хариуцлагын гэрээ хийсэн | 100 |
| 10 | Хаягдал бохир ус зайлуулах | Хаягдал шингэн болон бохир усыг зайлуулах гэрээ хийх | Кемп, гэрээт компани | 4 дүгээр улиралд | Хог хаягдлын менежментийн төсөвт орсон | Жилийн турш | Шугшаа Уул ОНӨААТҮГ гэрээ хийж хаягдал бохир усаа нийлүүлж ажиллсан | 100 |



Хөрсөн бүрхэвчид учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө

| | | | | | | | | |
|----|--|--|------------------------------------|-----------------------|------------------------------|-------------|--|-----|
| 11 | Уурхайлалтад өртөх талбайн хөрс | Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулан авсан өнгөн хөрсийг тусгайлан зассан овоолго байдлаар хадгалах | Ил уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Хөрс хуулалтын шатанд | Дотоод зардалд орсон. | Жилийн турш | Шимт хөрснийг хөрсний овоолгын хүрээ хязгаараар түрж хадгалсан, | 100 |
| 12 | Хөрс элэгдэх, эвдрэх | -Урт хугацааны шимт хөрсний овоолгын бүртгэл хөтлөх, хаягжуулах | Ил уурхайн үйл ажиллагааны хүрээнд | Хөрс хуулалтын шатанд | Дотоод зардалд орсон. | Жилийн турш | Бүртгэлийн дэвтэр хөтлөж ажилласан | 100 |
| 13 | хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн, доройтох | Уурхайн дотоод замыг засах, олон салаа зам гаргахгүйгээр нэг чиглэлийн замаар зорчих | Кемп, тээврийн, орон нутгийн зам | Улирал бүр | Газрын хэвлийн зардалд орсон | Жилийн турш | Уурхайн дотоод замыг засч сайжруулж шаардлаггүй замыг хаасан | 100 |
| 14 | Хог хаягдал болон уурхайн ашиглалтын үйл ажиллагааны явцад хөрсөн бүрхэвч бохирдох | Хауу шингэн хог хаягдлыг нийлүүлэх гэрээг Шугшаа уул ОНӨАТҮГ-тай байгуулах, төлбөр төлөх | Уурхай, кемп, тээврийн зам дагуу | Жилийн турш | - | 1 удаа | Гэрээ хийж хог хаягдлыг гэрээний дагуу нийлүүлдэг | 100 |
| 15 | Хөрсөн бүрхэвч бохирдох | Засварын газрын тос, тосолгооны материалыг цэгцлэх тос, маслыг ил задгай асгахгүй зориулалтын тусгай саванд хадгалах | Уурхайн засварын цех | 2022 оны 2 сард | - | Жилийн турш | Ашигласан тос, ШТМ ын түр цэг байгуулсан, аюултай хог хаягдал зайлуулах гэрээ хийж 18 тн хаягдал тос нийлүүлсэн. | 100 |

| Газрын хэвлийд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө | | | | | | | | |
|--|--|---|---------------------------------------|--------------|---------------------|--------|---|-----|
| 16 | Газрын хэвлийн хамгаалах хууль дүрэм мөрдөх | Газрын хянан баталгаа мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх | Уухрайн ашиглалтын үед | 2 сард | Дотоод зардал орсон | 1 удаа | Гео интегрэйн ХХК мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлсэн | 100 |
| 17 | | Шимт хөрсний чанар болон стандарт нормыг баримтлах /4м-ээс өндөр овоолохгүй, дагтаршуулахгүй/ | Ил уурхайн ашиглалтын үед | Улирал тутам | 250.000 | 4 | 2022 онд 4 удаа шимт хөрс хуулалтын ажил явагдаж, шимт хөрсний овоолгод байршуулсан | 100 |
| 18 | | Шимт хөрсний овоолго болон хөрс хуулалтад тавих хяналтыг сайжруулах, бүртгэл судалгааг тогмтол хийх | Хөрс хуулалтын шатанд | Улирал тутам | 250.000 | 4 | Бүргэл хөтөлж, хяналт тавьж ажиллсан | 100 |
| 19 | | Шимт хөрсний овоолго хүртэл гарсан олон салаа замыг нөхөн сэргээх | Уурхайн үйл ажиллаганы явцад | Жилийн турш | Дотоод зардалд | - | Салаа чигэлсэн замыг хаасан | 100 |
| Ургамлан нөмрөгөд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө | | | | | | | | |
| 20 | Ил уурхайн ахилт болон овоолгод ургамлан бүрхэвч дарагдаж устах | Хөндөгдөж буй талбайн ургамлын бүртгэл хөтлөх, тайлагнах | Хөрс хуулалтын үед | Улирал бүр | .250.000 | 4 удаа | Ургамлын бүртгэл хөтөлж бичиглэлийн мониторинг Хийж гүйцэтгэсэн. | 100 |
| 21 | Аймгийн ИТХ –ын баталсан 1 тн баялаг 1 мод хөтөлбөрийг хэрэгжүүлэх | Өмнөговь аймагт компанийн нэрэмжит цэцэрлэгжүүлэлтийн ажлыг эхлүүлэх | 1 тн баялаг 1 мод хөтөлбөрийн хүрээнд | 5 сард | 2.500.000 | 1 удаа | Гурвантэс сумын төвд 90000 мод хөтөлбөрийн хүрээнд 900 мод тарьсан 2021 | 100 |



Амьтны аймагт учруулж болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ төлөвлөгөө

| | | | | | | | | |
|-------------|---|--|--------------------------------------|---------------|-------------------|---------|---|--------------|
| 22 | Төслийн болон ойр орчны нутаг дэвсгэр дэх аймгийн нутагшил хумигдах | Уурхайн эдэлбэр газарт зэрлэг амьтдын хамгаалах төлөвлөгөө боловсруулна, шаардлагатай газар хурдны хязгаар тогтоох, ажилчдад анхааруулах мэдээлэл тараах, уурхайн талбай болон кемпийн ойр орчим дахь хар сүүлт, туулай гэх мэт амьтдыг хоол тэжээлийн нэг цэгт төвлөрүүлж, өвс тэжээл усыг бэлтгэн өгөх гэх мэт зэрлэг амьтдыг хамгаалах менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх | Биотехнологий арга хэмжээний хүрээнд | Улирал тутамд | 500.000 | 1 удаа | Баян Ундарга уурхайгаас 10 км ийн зайд орших Хөгшөө хайрхан ууланд аргал угалз, хар сүүлт зээр гэх мэт зэрлэг амьтадад 20 боодол өвс тэжээл байршуулсан | 100 |
| 23 | Мал амьтныг хамгаалах | Уурхайн догол, мөргөцөгт мал амьтан унахаас сэргийлэх хаалт, хашилт хийх | Уурхайн үйл ажиллаганы явцад | 3-р улирал | Дотоод зардалд | - | Уурхайг тойруулан шуудуу татаж, тэмдэг тэмдэглэгээг байрлуулсан. | 100 |
| 24 | | Мал, амьтны усанд орох зам жимийг хаахгүй байх, шаардлагатай хэсгүүдэд замын тэмдэглэгээ хийх | Ан амьтан хамгаалах ажлын хүрээнд | 2-р улирал | 500.0 | 1 удаа | Мал амьтны тэмдэглэгээ байрлуулсан | 100 |
| 25 | Зэрлэг ан амьтдыг хууль бус ангаас сэргийлэх | Ажиллагсад болон гэрээлэгчдийг галт зэвсэг хэрэглэхгүй байх болон хууль бус ангаас сэргийлэх сурталчилгаа явуулах | Уурхайн үйл ажиллаганы явцад | Жилийн турш | - | Сар бүр | Шинээр ирсэн болон гэрээт компаниудад сургалт зохион байгуулж ажиллсан. | 100 |
| Нийт | | | | | 23.800.000 | | | 100 % |



ЗУРГАА. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

| № | Нөхөн сэргээлтийн зорилт | Нөхөн сэргээлтийн арга хэмжээ | Хэмжих нэгж | Тоо хэмжээ | Нэгжийн зардал, төг | Нийт зардал, төг | Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж | Арга хэмжээний биелэлт | Оноо хувь |
|-------------|--------------------------------|--|-------------|------------|---------------------|-------------------|--------------------------------|--|------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | |
| 1 | Техникийн нөхөн сэргээлт | Эвдрэлд орсон ашиглагдахгүй байгаа газар, зам | га | 3 | 1.000.000 | 40.000.000 | Жилийн турш 2 удаа | Орон нутгийн Торгонжин ХХК тай хамтран Гоёот багийн нутагт Дэвсэг гэх гэзарт “Гар аргаар алт олборлосон” эвдрэлд орсон 3.2 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн . | 100 |
| 2. | Биологийн нөхөн сэргээлт | Техникийн нөхөн сэргээлт хийсэн газарт ургамал тарих | Га | 1 | 300.000 | 1.000.000 | 05 -р сард | Техникийн нөхөн сэргээлт хийгдсэн газар ургамал тарих боломжгүй байсан тул кемпийн хашаанд 200 хайлаас тарьсан | 100 |
| 3. | Татан буулгах, хаалтад бэлтгэх | | | | | | | Уурхайн Хаалтын эхэн шатны төлөвлөгөөг боловсруулсан. | 100 |
| Нийт | | | | | | 41.000.000 | | | 100 |

ДОЛОО. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

| <i>№</i> | <i>Дүйцүүлэн хамгаалах зорилт</i> | <i>Хамгаалах арга хэмжээ</i> | <i>Арга хэмжээний цар, хэмжээ</i> | <i>Тоо хэмжээ</i> | <i>Нэгжийн зардал, төг</i> | <i>Нийт зардал, төг</i> | <i>Арга хэмжээний биелэлт</i> | <i>Оноо Хувь</i> |
|----------|-----------------------------------|---|-----------------------------------|-------------------|----------------------------|-------------------------|--|------------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | |
| 1. | Нөхөн сэргээлт хийж гүйцэтгэх | Гурвантэс сумын нутагт байрлах Морин Заг Сууршилын бүсд хог хаягдлыг цэвэрлэж техникийн нөхөн сэргээлт хийх | Өмнөговь Гурвантэс сум | 2 га | Мкв 5000 | 40.000.000 | Морин заг сууршилын бүсд техникийн нөхөн сэргээлт хийх орон нутгийн БУМБАТ СҮМБЭРЭН ХХК тай гэрээ хийж техникийн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэсэн | 100 |
| 2 | Тэр бум мод үндэсний хөдөлгөөн | 2030 он хүртэл Гурвантэс суманд 1.5 сая мод Тарихаас 30.000 мод 2022 онд тарина | Өмнөговь Гурвантэс сум | 3га | Дотоод зардалд | 90.000.000 | Мод үржүүлгийн Энэрэл Мишээл ХХК гэрээ гүйцэтгэж татан авалт хийгдэх ажлын гүйцэтгэлтэй | 100 |
| | Нийт | | | | | 130.000.000 | | 100 |

НАЙМ. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө

Уурхайн дэд бүтцийн ажлыг эхлүүлэхтэй холбогдуулан замын нөлөөлөл, харьяалал, бүсийг тогтоон тухайн бүсэд амьдардаг айл өрхүүдтэй эвлэрэлийн гэрээ байгуулж тоосжилтод өртөж буй айл өрхүүдэд нөхөн олговрыг олгож дууссан тул Баян-Ундарга чулуун нүүрсний уурхай 2022 онд нүүлгэн шилжүүлэх ажил хийгдээгүй.


Ес. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

| № | Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв | Хамгаалах арга хэмжээ | Арга хэмжээний цар, хэмжээ | Арга хэмжээний биелэлт | Оноо хувь |
|----|---------------------------------|--|-----------------------------|------------------------------|-----------|
| | 1 | 2 | 3 | | |
| 1. | Археологийн дурсгал | 2022 онд уурхайн ахилт хийгдвэл Археологи, Палеонтологийн судалгаа хийгдэнэ. | Ил уурхайн ашиглалтын явцад | 2022 Уурхай ахилт хийгдээгүй | 100 |
| 2. | Палеонтологийн дурсгал | Хэрэв хайгуул судалгаа хийгдээгүй талбайнуудад шинээр газар хөндөх хүсэлт ирвэл авран хамгаалах ар | | | 100 |
| | | | | | 100 |



Жавхлант орд” ХХК нь 2016 онд “Соёлын Өвийг хамгаалах тухай” хуулийн дагуу ашиглалтын талбайд археологийн хайгуул судалгаа хийлгэсэн байна. Хайгуул судалгааны явцад нийт 27 дурсгалыг илрүүлж бүртгэн тэмдэглэн, баримтжуулалт хийсэн.

Дурсгалуудыг ангилвал хүрэл зэвсгийн үед холбогдох хэлбэрт булш 9, хиргисүүр 2, тахилын зориулалттай чулуун байгууламж 4, он цаг тодорхой бус зууван дөрвөлжин булш 4, дугуй хэлбэрийн булш 7, XVII-XIX зууны үед хамаарах хөшөө чулуу 2 эдгээр нь уулын налуу энгэрт болон тэгш дэвсэг газар хэд хэдээрээ болон ганц нэгээрээ орших бөгөөд археологийн судалгаа, усгаатан зүй судалгаа болон дурсгалуудыг авран хамгаалах ажил хийгдсэн болно.



Зураг 9. Хайгуулаар илэрсэн дурсгалуудын тархалтын зураг



АРАВ. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Уурхайн үйл ажиллагаанд өрөмдлөг, тэсэлгээний бодис, материал ашиглах ба химийн гаралтай шатахуун болон шатах, тослох материал ашиглана. Иймд Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Эрүүл мэндийн сайд, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2009 оны 02 сарын 03-ны өдрийн 28/40/29 дүгээр хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хуулиудыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллана

2022 онд Жавхланта орд ХХК нь уулын ажлын төлөвлөгөөний дагуу тэсэлгээ өрөмлөгийн ажлыг тусгай зөвшөөрөлтэй туслан гүйцэтгэгч компаниар гүйцэтгүүлнэ.

| <i>№</i> | <i>Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөөлөл</i> | <i>Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ</i> | <i>Арга хэмжээний цар, хэмжээ</i> | <i>Тоо хэмжээ</i> | <i>Нэгжийн зардал, төг</i> | <i>Нийт зардал, төг</i> | <i>Арга хэмжээний биелэлт</i> | |
|-----------|---|--|-----------------------------------|-------------------|----------------------------|-------------------------|--|------------|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 8 |
| 1. | Хөдөлмөр хамгаалал | ХАБЭА- н журмыг сахин ажиллах | Бүх ажилчид | 30 | 200.000 | 6.000.000 | Хөдөлмөр хамгаалалын журмыг шинэчлэн болосруулж, нэг бүрийн хамгаалах хэрэгсэлийг ажилчиддаа олгож ажилласан | 100 |
| 2 | Шатах тослох материалын асгаралт | Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж бэлтгэх | Төслийн талбайд | 10 | 200.000 | 2.000.000 | Шатах тослох материалын болон хаягдлыг түр хадгалах цэгийг хөрс бохирдохоос хамгаалж ажилласан. | 100 |
| | Нийт | | | | | 8.000.000 | | 100 |

АРВАН НЭГ . Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө биелэлт

Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын хэмжээг хамгийн бага байлгах, үүссэн хог хаягдлыг дахин ашиглах, зарим дахин боловсруулах боломжтой хаягдлыг хоёрдогч түүхий эд авах цэгт тушаах зэргээр хог хаягдлын хэмжээг бууруулж ажиллана.

“Жавхлант орд” ХХК нь Хатуу, шингэн хог хаягдлыг Гурвантэс сумын ОНӨААТҮГ болон “Шушаа уул” ХХК –тай гэрээ байгуулан ажиллана.

Аюултай хог хаягдал, түүнийг зайлуулах: Аюултай хог хаягдалд дараах хог хаягдлыг хамруулна.

Хаягдал тос, шингэн боловсруулдаг үйлдвэрүүдийн шаардлагын дагуу эдгээрийг тос ба гидрийн шингэн гэж ангилан 2 төрлийн саванд хадгална. 10тн-оос дээш хаягдал тосыг дахин ашигладаг “Алтан оршихуй” ХХК –тай гэрээ байгуулан ажиллана.



| <i>№</i> | <i>Хог хаягдлын ангилал</i> | <i>Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ</i> | <i>Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ</i> | <i>Хэмжих нэгж</i> | <i>Нэгжийн зардал, төг</i> | <i>Тоо хэмжээ</i> | <i>Нийт зардал, т өг</i> | <i>Тайлбар</i> |
|----------|-----------------------------|--|--------------------------------------|-----------------------------|----------------------------|-------------------|--------------------------|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | |
| 1. | Ахуйн | Хог хаягдлын төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулах | Уурхайн тосгон | 2 | 2.500.000 | 2 удаа | 5.000.000 | Хог хаягдлын төрөл тус бүрээр ангилан ялгаж, түр хадгалах цэгийг хашаа хамгаалалт хийж, тохижуулсан |
| 2. | Үйлдвэрийн | Дахин ашиглагдах хаягдлыг 2догч түүхий эд авдаг аж ахуйн нэгж байгууллагад нийлүүлэх. /хуванцар сав, | Кемп, засварын газар | 1 | - | 1 удаа | 1.000.000 | Алтан оршихуй ХХК тай гэрээ байгуулсан |
| | | 4. Гэрээт /тээвэр, хөрс хуулалт гэх мэт/ компаниудын үйл ажиллагаанд хяналт тавих, уурхайн талбайгаас гаднах хог хаягдлыг улирал тутам гэрээ компаниудтай хамтран цэвэрлэх | Тээврийн Гэрээт компаниуд | 45 км зам дагуу хог хаягдал | 250.000 | 4 удаа | 1.000.000 | Шугшаа уул ОНӨААТҮГ таай хамтран ажилласан |
| 3. | Үйлдвэрийн | Хаягдал дугуй, машин техникийн хаягдал төмөр, сэлбэгийг чөлөөт урсацаас чөлөөлж нэг цэгт төвлөрүүлэх, | Уурхай | - | - | 4 | - | Тусгай цэг байгуулан тохижуулсан |
| 4. | Аюултай | Аюултай хог хаягдын цэгийн талбайг цэвэрлэж засаж, тохижуулах, асгаралт үүсэхээс хамгаалах | Засварын цех | 1 | - | 1 удаа | 3.000.000 | Аюултай хог хаягдын цэгийн талбайг цэвэрлэж засаж, тохижуулсан |
| | Нийт | | | | | | 10.000.0 | |



АРВАН ХОЁР. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Зангат уулын чулуун нүүрсний уурхайг ашигласнаас үүдэн байгаль орчинд учирч буй сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлэх зорилгоор лабораторийн шинжилгээ, ажиглалт, хяналт явуулах үйл ажиллагааны удирдамжийг орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр гэнэ. Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрт тухайн төслөөс байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд гарах аливаа өөрчлөлтийг хянах, шинжилгээний арга аргачлал, хяналт шинжилгээ хийх хугацаа, сорьц авах болон хэмжилт хийх цэгийн байршил, баримтлах стандартууд зэргийг тодорхойлно. Тус хөтөлбөр нь төслийн явцад үүссэн сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ хэр үр дүнтэй байгааг илтгэх, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсронгуй болгох, уурхайн хаалтын төсөл боловсруулахад үндэслэл болно. Мөн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, болон хяналтын байгууллага, иргэдэд бодитой мэдээлэл өгөхөд чухал ач холбогдолтой юм.

“Жавхлант орд” ХХК-ийн ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд олборлолт явуулахад БОННУ-ний тайлан, Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгасан болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, төслийн үйл ажиллагааны явцад гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор хянах үзүүлэлтүүд, байршил, хугацаа, баримтлах стандарт, аргачлалыг уг хөтөлбөрт тусгав.

Хяналт шинжилгээний дээж, сорьцыг Монгол улсад хүлээн зөвшөөрөгдсөн(итгэмжлэгдсэн) лабораториудад батлагдсан арга зүй, стандартын дагуу шинжлүүлнэ. Хяналт шинжилгээний үр дүнг хянах үйл ажиллагааг мэргэжлийн байгууллагууд, орон нутгийн иргэдийн хөндлөнгийн хяналтын доор гүйцэтгүүлэх зэргээр оролцогч талуудын хяналтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах нь зүйтэй юм.



| № | Хяналт шинжилгээний дээж | Хянах үзүүлэлтүүд | Дээж авах цэгийн тоо | Дээж авах байршил | Давтамж | Төсөв мян.төг | Зөвшөөрөгдөх хэмжээ, баримтлах стандарт |
|----------------------|--------------------------|---|----------------------|---|--------------|---------------|--|
| 1 | Агаарын дээж | Агаар дахь NO ₂ , SO ₂ , CO, Pm2.5, Pm10 –ийн агууламж | 5 | Агаарын бохирдол үүсгэх эх үүсвэрүүдийн орчинд хяналтын цэг тогтоож | Улирал тутам | 2000.0 | MNS 6063:2010 MNS 4585:2007 MNS 5885: 2008 |
| | | Агаар дахь тоосны хэмжээ | | Уурын зуух, тосгон, уурхай, замын орчинд тоосны хяналтын цэгүүд байгуулах | Улирал тутам | | MNS 5365:2004, MNS 5246:2003 MNS 5010:2001 |
| | | Дуу чимээний түвшин | 10 | Ил уурхай, авто зам, засварын газар, тосгон зэрэг дуу чимээ ихтэй газруудад | Улирал тутам | 100.0 | MNS 5002:2000 |
| 2 | Усны дээж | Усны ерөнхий химийн шинжилгээ: рН, Ca ²⁺ , Mg ²⁺ , NH ₄ ⁺ , Na ⁺ , K ⁺ , Fe ³⁺ , SO ₄ ²⁻ , HCO ₃ ⁻ , Cl ⁻ , NO ₂ ⁻ , NO ₃ ⁻ | 5 | Уурхайн нөлөөллийн бүс дэх уст цэгүүд болон гүний худагт | Улирал тутам | 600.0 | MNS 900: 2010 |
| | | Бактериолгийн шинжилгээ: нийт нянгийн тоо, Escherichia Coli, Salmonella, Shigella, Clostridium. Perfring-ens | | | | 1000.0 | MNS 900: 2005 MNS 4943: 2000 MNSISO 10523: 2001 |
| 3 | Хөрсний дээж | Хөрсний үржил шимийн үзүүлэлт: рН, ялзмаг, карбонат, Ca ²⁺ Mg ²⁺ , P ₂ O ₅ , K ₂ O, механик бүрэлдэхүүн | 5 | Уурхайн нөлөөллийн бүс болон авто зам, тосгоны ойролцоо хяналтын цэгүүд байгуулах | Улирал тутам | 600.0 | MNS 3310:91 УСТ-12,059-91 УСТ- 12,056-91 MNS5850:2008 |
| | Хөрсний дээж | Хүнд металлууд:Cr, Pb, Cd, Ni Zn, нефтийн бүтээгдэхүүн | 5 | Нөлөөллийн бүс дэх хяналтын цэгүүдээс бохирдол хамгийн өндөр байж болох 5 цэгээс | Улирал тутам | 800.0 | MNS 5850:2008 |
| 4 | Ургамал | Уурхайн орчны ургамлын төрөл зүйл, бүрхэц %, бодгалиудын тоо; Ургамлын дундаж өндөр, см Ургамлын биомасс, кг/га | - | Уурхайн тусгай зөвшөөрлийн талбай болон ойролцоох газар нутагт мониторингийн цэгт | 3-р улиралд | 500.0 | MNS ISO 11269-1: 2002 MNS ISO 11269-2: 2002 MNS 5546: 2005 |
| Нийт зардал, мян.төг | | | 7.300.0 | | | | |



АРВАН ГУРАВ. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

| № | Төлөвлөсөн арга хэмжээ | Урьдчилан тооцсон төсөв | Хэрэгжүүлэх хуваарь | | | Хариуцсан албан тушаалтан | Тайлбар |
|---|---|-------------------------|---------------------|--------|--------|---------------------------------------|---|
| | | | 2021 он | | | | |
| | | | Сар | Сар | Сар | | |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | ТЭЗҮ, Уулын ажлын төлөвлөгөөг баримтлаж ажиллах | Тодорхойгүй | Жилийн турш | | | Уурхайн дарга Байгаль орчны хэлтэс | Уулын ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу гүйцэтгэсэн |
| 2 | Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, биелэлтийг хугацаанд нь тайлагнах | Тодорхойгүй | 4 сар | 10 сар | 11 сар | | Сумын иргэдэд 8 –р сард тайлагнасан |
| 3 | Мэргэжлийн байгууллагаар уурхайн хаалтын төлөвлөгөө боловсруулах | Тодорхойгүй | | 6 сар | | | Мэргэжилийн байгууллагаар боловсруулсан |
| 4 | Мэргэжлийн байгууллагаар дүйцүүлэн хамгааллын төлөвлөгөө боловсруулсан орон нутагт хэлэлцүүлэг зохион байгуулах | Тодорхойгүй | | 5 сар | | | Аймаг сум баг, иргэдтэй уулзалт, хэлэлцүүлэх зохион байгуулах |



| | | | | | | | |
|---|--|-------------|----------|-------|---|----------------------------|---|
| 5 | Мэргэжлийн байгууллагаар газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг 5 жил тутамд хийлгэх | Тодорхойгүй | | 2 сар | | Тусгай зөвшөөрөлтэй компан | Мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн |
| 6 | Мэргэжлийн байгууллагаар байгаль орчны аудитыг 2 жил тутамд хийлгэх | Тодорхойгүй | 3-р сард | | | Тусгай зөвшөөрөлтэй компан | Вайз солюшн ХХК аар хийлгэсэн |
| 7 | Мэргэжлийн байгууллагаар археологи, палеонтологийн судалгаа хийлгэж, дүгнэлт гаргуулах, | Тодорхойгүй | - | - | - | | Уулын ажлын ахилт хийгвэл судалгаа хийгдээгүй |
| 8 | Бичиг баримтын бүрдэл | 2.000.000 | | | | | |
| | Нийт | | | | | 2.000.000 | |

АРВАН ДӨРӨВ. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

| <i>№</i> | <i>БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд</i> | <i>Тайлагнах хэлбэр</i> | <i>Мэдээллийн агуулга</i> | <i>Зохион байгуулах хугацааны тов</i> | <i>Тайлагнах зардал, төг</i> | <i>Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан</i> | <i>Зохион байгуулах газар</i> |
|----------|--|---|--|---------------------------------------|------------------------------|--|-------------------------------|
| | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
| 1 | Тэмдэглэлт өдрүүд: Дэлхийн усны өдөр, Мод тарих өдөр, Дэлхийн нүүдлийн шувууны өдөр, Дэлхийн цөлжилттэй тэмцэх өдөр г.м тэмдэглэлт өдрүүдээр Гурвантэс сумын дунд сургуулийн сурагчдад чиглэсэн танин мэдэхүйн арга хэмжээнүүд зохион байгуулна. | Үйл ажиллагааны тайлан, хамрагдсан байгууллага, хүний тоо | Байгаль орчны хамгаалах чиглэлээр мэдлэг олгох, олон нийтийн тэмдэглэлт өдрүүдийг хамтран зохион байгуулах | Тогтсон өдрүүдэд | 4.000.000 | Байгаль орчны ажилтан, Гурвантэс сумын ЗДТГ | Гурвантэс сум, Уурхай |

| | | | | | | | |
|---|---|---------------------|----------------|--------------|------------------|--|-----------------------|
| 2 | Уурхай орчимд амьдардаг малчид болон багийн иргэд | Бичгээр болон амаар | БОМТ хэрэгжилт | 2,4-р улирал | 3.000.000 | Орон нутаг харицсан ажилтан, байгаль орчны мэргэжилтэн | Гурвантэс сум, Уурхай |
| | Нийт | | | | 7.000.000 | | |

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний 2022 оны нийт төсөв

Хүснэгт 7. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний төсөв

| № | Зардлын ангилал | Төсөв, мян.төг |
|----|---|--------------------|
| 1 | Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ | 24.100.000 |
| 2 | Техникийн нөхөн сэргээлт | 40.000.000 |
| 3 | Биологийн нөхөн сэргээлт | 2.000.000 |
| 4 | Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ | 130.000.000 |
| 5 | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ | - |
| 6 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө | - |
| 7 | эрсдлийн менежментийн төлөвлөгөө | 8.000.000 |
| 8 | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө | 10.000.000 |
| 9 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө | 2.000.000 |
| 10 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах | 7.000.000 |
| 11 | Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөр | 7.300.000 |
| | Тухайн жилийн байгаль хамгаалах менежментийн төлөвлөгөөний нийт төсөв | 250.600.000 |

Зангат уулын чулуун нүүрсний уурхайн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөн нийт 67.100.000 төгрөг зарцуулж 90 % ийн биелэлттэй ажилласан байна

